

Дэлхий ертөнц урьд олно болж байгаагүй шилжилтийн үеийг даван туулж байна гэж очигдор Москвад болсон хэвлэлийн бага хурал дээр Орос улсын ГХЯ-ны тэргүүн Сергей Лавров мэдэгдэв. Тэрээр уг процесс нь “дэлхийн улс- төрийн байдлын оорчлолт шинэ хувчлалыг бий болгоход хүргэнэ” гэв. Тэр Ойрхи-Дорнодын болон Хойд Африкийн хүнд ноцол болоод Солонгосын хойгийн болон ираны цомийн хотолборийн тухай тулгамдсан асуудлуудыг санууллаа.

Орос улсын ГХЯ-ны тэргүүний ярьснаар, Москва японы эрх баригчдын нутаг дэвсгэрийн маргаантай асуудлаар нэг талыг барьсан хандлагууд нь ашиг тустайг олж харахгүй байгаа аж. Сергей Лавров тэмдэглэхдээ, энхийн гэрээний тухай асуудал нь эрх зүйн талбарт шийдэгдэх ёстой юм гэв. Сайдын хэлсэнээр, японы еронхий сайд асан Иосиро Мори нь ойрын үед Москвад айлчлал хийх явцдаа хоёр орны энхийн гэрээний асуудлыг сонирхож болох аж. Түүнчлэн Лавров Москвад Японы еронхий сайд Синдзо Абэ хүрэлцэн ирэхийг хүлээж байгаа тухай цохон тэмдэглэв.

Тэрээр мон БНАСАУ-ын эрх баригчид нь олон улсын хамтын нийгэмлэгийн уриалгад чих тавьж Солонгосын хойгийг цомийн зэвсэггүй болгох асуудлаар яриа хэлэлцээрт эргэж орно гэж Москва үзэж байна гэлээ. Энэ тухай Орос улсын ГХЯ-ны тэргүүн мэдэгдэв. Үүний тулд Пхеньян нь НҮБ-ын АЗ-ийн тогтоолуудад агуулагдаж байгаа агуулгын шаардлагын хүрээнд үлдэх хэрэгтэй юм гэж тэр хэллээ.

Орос улс зургаан талт яриа хэлэлцээрийг сэргээхийн тулд боллоцоотой бүхий л зүйлийг хийх болно гэж Лавров амлав. Онгорсон 12-р сард Умард-Солонгосын хооргосон баллистик пуужинг эсэргүүцэн гаргасан НҮБ-ын АЗ-ийн тогтоолыг Лавров тайлбарлахдаа, тухайн асуудалд оросын үнэлгээ нь АЗ-ийн хоёр гишүүний байр суурьтай нийцэж байна гэж мэдэгдэв.

Сергей Лавров уламжлахдаа, Орос улс, Вьетнам болон Шинэ Зеландын хамт чөлөөт худалдааны бүс байгуулахаар зориг шулуудан ажиллаж байна. “Энэ нь бидний хувьд бол харьцангуй шинэ хэлбэрийн ажил” гэж тэр тэмдэглэв. Хэрвээ бүх юм сайхан болох юм бол эл туршлагаа АСЕАН-ы бусад гишүүн орнууддаа дэлгэрүүлж болох юм”. ОХУ болон АСЕАН-ы хамтын ажиллагааны асуудалтай холбоотой асуултанд хариулахдаа,

“худалдаа, хоронго оруулалтын нийт хэмжээ осч, холбооны орнуудтай эдийн засгийн хамтарсан тослвуд байнга осч байна” гэв.

Сергей Лавров Сирийн асуудалтай холбоотой асуултанд хариулахдаа, тус улсын сорог хвчин зэвсэгт тэмцлийнхээ бодлогоос ероос татгалздаггүй вүгээрээ тэд орнодийнхнийг оогшүүлж байдаг. Орос улсын твшүүд, Хятадаас бусад нь, сорог хвчнийг Сирийн эрх баригчидтай яриа хэлэлцээрийн ширээний ард суулгах оролдлогыг хийгээгүй гэж дипломат хэллээ.

2012 онд Сирийн эрх баригчдыг сорог хвчнийхний хамт нэг яриа хэлэлцээрийн ширээний ард суулгах гэсэн оролдлогууд нь амжилтгүй болсон гэж Орос улсын ГХЯ-ны тэргүүн вэлээ. Үүний хариуцлага нь еронхийлогч Башар Асадын дэглэмтэй тууштай тэмцэж байгаа сорог хвчнийхнийг оогшүүлж байдаг орнодийн орнууд хвлээх ёстой гэж сайд тэмдэглэв.

«Талуудыг яриа хэлэлцээрийн ширээний ард суулгах оролдлогууд нурсан тухай гэх юм бол, миний л мэдэхээр, гаднаас оролцогч бvx талуудын зүгээс ийм зүйл ажиглагдаагүй юм. Үүнд хврэхийн тулд Орос улс явж байна. Бид сирийн бvx талуудтай үргэлжлүүлэн уулзсаар байна. Харамсалтай нь Женевт бий болсон үйл ажиллагааны бүлгэмийн бусад гишүүд сорог хвчнийхэнтэй холбогдохдоо буруу ташаа дохионуудыг илгээж, харин засгийн газартай ямарч холбоо барихгүй байна. Тэдний дэмжлэгийг авдаг сорог хвчнийхэн дэглэмтэй ямарч яриа хэлэлцээр хийх боломжгүй юм» гэж Лавров хэллээ.

Сергей Лавровын үзэж байгаагаар, Орос улсын хувьд бол урьтал нь улс төрийн ямар нэгэн зорилгод хврэх нь бус, харин бус нутагт тогтвортой байдлыг бий болгоход оршиж байна.